

**МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО**

**МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ  
(ТoC)-ИЙН ЗАРЧМУУД**

**УДИРДАМЖ**

УЛААНБААТАР  
2014 он

## ОРШИЛ

Монгол Улсын банкууд санхүүгийн салбарын гол төлөөлөл болохынхоо хувьд тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах арга хэрэгслийн нэг болох ногоон эдийн засгийг Монгол Улсад хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм. Тиймээс бид банкууд үйл ажиллагаагаа явуулж, бизнесийн шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгмийн асуудлыг харгалзан авч үзэх удирдамж болох зарчмуудыг боловсруулж, хэрэгжүүлэхийг дэмжин хамтарч ажиллаж байна.

Эдийн засгийн хөгжил дэвшил нь шинэ боломж, нөхцөлийг бий болгодог хэдий ч үүний зэрэгцээ бид агаар-ус-хөрсний бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөц, усны хомсдол, орчны доройтол, хүн амын хэт төвлөрөл, ядуурал болон бусад асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Монгол Улс үсрэнгүй хөгжлийнхөө гараан дээр ирээд байгаа энэ үед, бид эдийн засгийн эрчимтэй хөгжлийг байгаль орчныг хамгаалж, нүүдэлчний хосгүй өв соёл, ахуй, түүхийн үнэт зүйлсийг хадгалах бодлоготой нягт уялдуулан, өрхийн тогтвортой амьжиргаа, Монгол хүний боловсрол, эрүүл мэнд, амьдралын хэв маягт нийцүүлэн нарийн төлөвлөх хэрэгтэй юм.

Дээр дурдсан бэрхшээлийг даван туулах арга замыг хайж буй бидний хамтын хүчин чармайлт, эрүүл, аюулгүй, ногоон ажиллах, амьдрах орчны талаархи бидний нэгдмэл санаа нь банкны өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа, хамтрагч, харилцагч нарт нийцсэн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зөвхөн ашиг олоход чиглэсэн бус Монгол Улсыг байгаль орчин, нийгмийн асуудлыг анхаарсан эдийн засгийн хөгжилд хүргэнэ гэдэгт итгэлтэй байна. Бид эдийн засгийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж, ажлын байрыг шинээр бий болгоход хувь нэмрээ оруулж, Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн тулах цэг болох салбар болохын төлөө зорьж байна. Энэхүү зорилго, хүчин чармайлт нь Монгол Улсын банкуудыг олон улсын зах зээлд гарч, хөрөнгө оруулагчдаас авах санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжийг бий болгоно гэдэгт итгэлтэй байна.

Банкны харилцагчийн байгаль орчин, нийгмийн үзүүлэлт хангалтгүй байх нь банкныг хууль эрх зүйн хувьд, зээлийн хувьд, цаашлаад бизнесийн нэр хүндийн хувьд ч эрсдэлд оруулах боломжтой гэдэг нь улам тодорхой болсоор байна. Банкнаас цаашид үйл ажиллагааныхаа хүрээнд дээрх эрсдэлийг зөв удирдаагүйгээс байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл бий болно гэж үзэж байна. Иймээс банкны салбарт банкнаас харилцагчдад чиглэсэн үйл ажиллагаа болон банкны дотоод үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэх нь зээл, харилцагч, бүтээгдэхүүний багц, нэр хүндтэй холбоотой эрсдэлийг оновчтой удирдахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Үүний зэрэгцээ банк нь харилцагчиддаа санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан тогтвортой, ногоон хөгжил, санхүүгийн хүртээмжийг дэмжигч манлайлагч болох боломжтой.

Бид өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг нэвтрүүлж байгаагийн хувьд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлэх, харилцагчидтай хамтран ажиллах арга замыг боловсруулахдаа Монгол Улсад Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн суурийг тавихад тэгш оролцоотой байхыг эрмэлзэх болно. Бид байгаль орчин, хүн, нийгэм, соёлын өвийг **хамгаалах болно**. Бид ногоон эдийн засгийн өсөлт, санхүүгийн хүртээмж, ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг **дэмжих болно**. Бид эдгээр зарчмуудыг өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, **үлгэрлэн манлайлж**, хэрэгжилтийн үйл явцыг тогтмол тайлагнах болно.

## **МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ (ТoC)-ИЙН ЗАРЧМУУД**

Монгол Улсын тогтвортой хөгжлийн асуудлуудад анхаарлаа хандуулж, банкуудад Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогын идэвхтэй оролцогч байхад нь туслах зорилгоор Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг ОУСК-ийн санхүүжилт, МБХ-ны санаачлагаар ЭсЭфАй ХХК болон Састэйнабилити Ийст Эжия ХХК нар боловсрууллаа. Энэ нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, багасгах, бий болохоос зайлсхийхийг эрмэлзэх, түүнчлэн улс орны ногоон эдийн засгийн өсөлт, хөгжлийн зорилгод нийцсэн төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхийг дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийн олон талт хөгжилд хувь нэмэр оруулах Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийг бий болгох нэг арга зам юм.

### **Зарчим 1 | Байгаль орчноо хамгаалах**

Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

### **Зарчим 2 | Хүний эрх, нийгмийг хамгаалах**

Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

### **Зарчим 3 | Соёлын өвийг хамгаалах**

Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.

### **Зарчим 4 | “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих**

Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.

### **Зарчим 5 | Санхүүгийн хүртээмжийг дэмжих**

Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.

### **Зарчим 6 | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих**

Бид хориглосон жагсаалтанд багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.

### **Зарчим 7 | Ил тод байдал, хариуцлагыг дэмжих**

Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.

### **Зарчим 8 | Манлайлан үлгэрлэх**

Бид харилцагчиддаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллана.

## **Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн ЗАРЧМУУДЫН УДИРДАМЖИЙН ТУХАЙ**

Энэхүү удирдамж нь Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн чухал асуудлуудын хүрээнд банкуудад бодлого боловсруулах, үйл ажиллагаагаа явуулах, зээл олгох шийдвэр гаргахад туслах зорилготой баримт бичиг юм. Монгол Улсад дагаж мөрддөг хууль тогтоомжоос гадна, бид олон улсын зах зээлийн хүлээлтэнд нийцүүлэх зорилгоор олон улсын холбогдолтой стандарт, салбарын сайн туршлагуудыг жишээ болгон удирдамжиндаа тусгалаа. Цаашид Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-тэй холбоотойгоор шинээр бий болсон сайн туршлагын талаар энэхүү удирдамжинд тусгаж байх болно. Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагаа, мэдлэг туршлагаа харилцан солилцох нь чухал учир бид тайлагнах, чадавхижүүлэх үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод байлгана.

Банк тус бүр өөрийн үйл ажиллагаа, харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн энэхүү удирдамжийг харилцан ялгаатайгаар хэрэгжүүлж болно. Энэхүү удирдамж нь Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг банк өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх суурь болгох, цаашид хэрхэн хэрэглэх санал санаачилга, хүсэл тэмүүллийг бий болгоход түлхэц үзүүлэх зорилготой юм. Банк энэхүү удирдамжийг ашигласнаар холбогдох бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх тогтолцоо, зааварчилгаа, шаардлагатай бүтэц, орон тоо, сургалт, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож, тайлагналын бүтцийг тодорхойлох боломжтой болох юм.

| Нэр томъёо                              | Тайлбар   |
|---|---|
| Банкны үндсэн үйл ажиллагаа             | Банкнаас харилцагчдад хүргэж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ. Тухайлбал, байгууллагын санхүүжилт, хөрөнгө оруулалтын банк (бүтцийн зээл, санхүүжилт, худалдаа болон байгууллагын зөвлөх үйлчилгээ), хувьцааны хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилт, төслийн санхүүжилтийн зөвлөгөө, ЖДБ-ийн зээл, иргэдийн банк, худалдаа, лизинг, бусад төрлийн зээл гэх мэт.   |
| Дотоод үйл ажиллагаа                    | Банкнаас бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн харилцагчид хүргэхэд шаардлагатай боловсон хүчин, эд хөрөнгө болон дэд бүтэц (оффис, салбар, тоног төхөөрөмж гэх мэт) багтана. Үүнд мөн банкнаас эрхэлж буй үйл ажиллагаа болон дотоод үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад хамтран ажилладаг бэлтгэн нийлүүлэгч, гэрээт байгууллага, үйлчилгээ үзүүлэгч гуравдагч талуудын үйл ажиллагаа хамаарна.   |
| Соёлын өв                               | Соёлын өв нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий биет өв, дурсгалыг хэлнэ.  |
| Байгаль орчин, нийгмийн үл мөр          | Банкны дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нийт нөлөөллийг (үүнд, үйл ажиллагааны хүрээнд ашигласан байгалийн нөөц /ус, эрчим хүч/-ийн нийт хэмжээ, үйлдвэрлэсэн хог хаягдлын нийт хэмжээ, банкны ажиллагсад болон үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт амьдарч иргэдэд үзүүлж буй нөлөөлөл).  |
| Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл | Банкны дотоод үйл ажиллагаа болон банкны харилцагчийн бизнесийн үйл ажиллагаанаас бодит орчин, байгалийн болон соёлын орчинд үүсэх, түүнчлэн олон нийт болоод өөрийн ажиллагсад үзүүлэх бодит эсхүл болзошгүй өөрчлөлтүүдийг байгаль орчин, нийгмийн нөлөөлөл гэж ойлгоно. Эдгээр нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх түр зуурын эсхүл байнгын шинжтэй, нөхөн сэргээгдэх эсхүл нөхөн сэргээгдэхгүй шинжтэй нөлөөлөл байж болно. Байгаль орчны нөлөөлөлд хүний үйл ажиллагаа (хүлэмжийн хий, бохирдол, амьдрах орчны өөрчлөлт гэх мэт)-наас үүдэлтэй уур амьсгалын, усны, газар нутгийн өөрчлөлтүүд багтана. Нийгэмд үзүүлэх нөлөөлөлд тухайн харилцагчийн удирдлаган дор ажиллаж буй хүмүүс болон түүнийг хүрээлж буй хүмүүст үзүүлэх нөлөөлөл (эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний эрх болон хөдөлмөрийн стандарт, газрын маргаан/нүүлгэн суурьшуулалт, авлига гэх мэт)-үүд багтана. |
| Байгаль орчин, нийгмийн давуу тал       | Байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотойгоор үүсэх шинэ бизнесийн боломж (цэвэр/сэргээгдэх техник технологийг нэвтрүүлэх, ногоон ажлын байр шинээр бий болох, орон нутгийг хөгжүүлэх гэх мэт)-ийг ойлгоно. Бизнесийн аливаа шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгмийн асуудлуудыг анхаарч харгалзан үзэх нь харилцагч болон тухайн харилцагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй банкинд шинэ боломж, давуу тал үүсэх боломжтой.   |
| Байгаль орчин, нийгмийн эрсдэл          | Бизнесийн болоод эрсдэлийн удирдлагын шийдвэр гаргахад анхаарах шаардлагатай эрсдэл үүсгэх боломжтой хамтран ажиллагч тал, гэрээ хэлцэлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлууд  |
| Экваторын зарчмууд                      | Экваторын зарчмууд нь төслийн санхүүжилтийн явцад байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлон үнэлж, зохицуулахад удирдлага болгох сайн дурын багц стандартууд юм.  |
| Ёс зүйтэй санхүүжилт                    | Санхүү, ёс зүй, нийгэм, байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлуудыг хослуулан харгалзаж стратегитэйгээр хөрөнгө хуваарилах, тараан байршуулах тухай санхүүжүүлэлтийн хандлага, философи юм.  |
| Санхүүгийн хүртээмж                     | Санхүүгийн хүртээмжийг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хувь хүн, өрх, бүлгээрээ зохистой хэмжээнд авах боломж гэж тодорхойлдог. Санхүүгийн үйлчилгээг тодорхой хэмжээнд авах боломжгүй хүмүүсийг санхүүгийн үйлчилгээнээс гадуур бүлэг гэж үздэг.   |
| Ногоон эдийн засаг                      | Ногоон эдийн засаг нь байгаль орчны эрсдэл, экологийн хомсдолыг бууруулах,  |

|   |  |
|---|--|
|   | хүрээлэн буй орчноо доройтуулахгүйгээр тогтвортой хөгжилд хүрэх зорилготой эдийн засгийн хөгжлийн загвар юм.   |
| Ногоон өсөлт                                  | Дэлхийн банкны тодорхойлсноор "Ногоон өсөлт" нь байгалийн нөөцийн үр ашигтай хэрэглээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бохирдлыг багасгах цэвэрлэгээ, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны удирдлага, байгалийн нөөцийн үүрэг хариуцлагыг харгалзан авч үзэх уян хатан байдал бүхий байгаль орчны хувьд тогтвортой өсөлт юм. |
| Хүний эрх                                     | Хүний эрх нь аливаа бодгаль хүний үндэс угсаа, оршин суух газар, хүйс, гарал үүсэл, арьс өнгө, шашин шүтлэг, хэл соёл болон өөр бусад байдлаас үл хамаарах төрөлхийн жам ёсны эрх юм. Эдгээр эрхэд үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, ажил хөдөлмөр эрхлэх, эрх тэгш, шударга байх зэрэг эрхүүд мөн багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.                           |
| Зээл  | Банк нь харилцагчийн төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлж зээл олгох үйл ажиллагаа  |
| Гуравдагч тал/ханган нийлүүлэгч               | Банк, түүний харилцагчийн гэрээт гүйцэтгэгч, хөдлөнгийн бие даасан байгууллага, хангамжийн сүлжээний байгууллага   |
| Харилцагчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ | Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд боловсруулах харилцагчаа хамгаалах арга хэмжээ  |
| Дью дилиженс үнэлгээ                          | Банк нь өөрийн харилцагчийн төсөл, үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний арга  |
| Хөгжиж буй зах зээл                           | Дөнгөж шинээр хөгжиж буй зах зээлийг хэлнэ   |
| Оролцогч талууд                               | Тухайн асуудалд нөлөө үзүүлэх боломжтой буюу ашиг сонирхолтой хувь болон бүлэг хүн, байгууллага болон бусад төлөөлөл   |
| ОУСК  | Олон улсын санхүүгийн корпораци  |
| ЕСБХБ   | Европын сэргээн босголт, хөгжлийн банк   |

## Тайлбар толь

Энэхүү удирдамжийг уншихад ойлгомжтой болгохын тулд зарим нэр томъёог түүвэрлэн тодорхойлов. Дээрх нэр томъёонуудыг Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд зориулан олон нийтэд нээлттэй байдаг эх сурвалжаас сонгон авч тусгалаа.

## МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ (ТоС)-ИЙН ЗАРЧМУУД

| Зарчим 1   | Байгаль орчноо хамгаалах  |
|--|---|
|  | <p>Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.</p>  |
| Тайлбар  | <p>Банк нь өөрийн харилцагчийн үйл ажиллагаанаас байгаль орчин (үүнд, хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал болон байгалийн нөөц зэрэг багтана)-д сөрөг нөлөөлөл үзүүлж буй эсэхийг үнэлнэ. Энэхүү зарчмыг хэрэгжүүлэхдээ банк нь өөрийн харилцагч, түүний зээлийн зарцуулалттай холбогдуулан байгаль орчны эрсдэл, болзошгүй нөлөөллийг тогтмол тодорхойлж, үнэлэн зохицуулж, харилцагчаа байгаль орчны стандартуудыг даган мөрдөж байгаа эсэхийг хянаж байна.</p> <p>Банкны харилцагчийн үйл ажиллагаанаас байгаль орчны эрсдэлд өртөх байдал нь харилцагчтай тогтоосон хамтын ажиллагааны байдал, тэдгээрт үзүүлж буй санхүүгийн үйлчилгээний төрөл, хугацаа, тухайн бизнесийн салбар болон харилцагч өөрийн үйл ажиллагааны байгаль орчны эрсдэлүүдийг удирдах чадвартай эсэх гэх мэт хүчин зүйлсээс хамаарна.</p> <p>Банк байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, багасгаж, бий болохоос зайлсхийж буй болон Монгол Улсын хуулиуд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудад нийцсэн байгаль орчны стандартуудыг даган мөрдөж буй бизнесийн үйл ажиллагаануудыг идэвхитэйгээр дэмжих болно. Банк нь шавхагдаж буй байгалийн нөөц, нийт экосистемийн эрүүл байдлыг хадгалан хамгаалах бодлого явуулдаг харилцагчид, тийм төслүүдэд түлхүү зээл олгох явдлыг дэмжин ажиллах болно.</p>  |
| <p>Холбогдох олон улсын стандарт</p> <p>Хэрэгжүүлэлт</p> | <p>ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 1 (Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ), Гүйцэтгэлийн стандарт 3 (Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдолоос урьдчилан сэргийлэх нь), Гүйцэтгэлийн стандарт 6 (Биологийн олон янз байдлын хадгалан хамгаалалт, Байгалийн амьд нөөцийн тогтвортой менежмент) (<a href="#">Холбоос</a>)</p> <p>ОУСК-ийн Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамжууд (Салбарын онцлогийг харгалзсан) (<a href="#">Холбоос</a>)</p> <p>Экваторын зарчмууд (<a href="#">Холбоос</a>)</p> <p>ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагууд (<a href="#">Холбоос</a>)</p> <p>ISO 14001 – Байгаль орчны менежмент (байгаль орчинд үзүүлж буй өөрийн нөлөөллийг тодорхойлон удирдаж, байгаль орчны гүйцэтгэлээ сайжруулахыг эрэлхийлж буй компани, байгууллагуудад зориулсан гарын авлага) (<a href="#">Холбоос</a>)</p> <p>Банк нь өөрийн харилцагчид, мөн зээл олгож буй төслийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны эрсдэл, болзошгүй нөлөөллийг тухай бүр системтэйгээр тодорхойлон, үнэлж, удирдах хандлагыг зээлийн шийдвэр гаргах үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнчлэн байгаль орчны холбогдолтой стандартуудыг зохих байдлаар хэрэглэж буйг тодорхойлох байдлаар энэхүү зарчмыг хэрэгжүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхээс зайлсхийх боломжгүй бол харилцагч нь тухайн үүсч болох сөрөг нөлөөллийг багасган, нөхөн сэргээлт хийж, мөн байгаль орчны гүйцэтгэлээ тохиролцсон хугацаанд хэрэгжүүлж ажиллах өөрийн төлөвлөгөөг банктай тохирно.</p> <p>Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого, журмын хүрээнд банк харилцагч, зээл олгож буй төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэлийн асуудал, болзошгүй сөрөг нөлөөллийг хамруулсан бодлогын тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд, тухайн салбарын онцлог, байгаль орчин, нийгэмд эрсдэл үзүүлэх боломжит нөхцөл байдал, харилцагчийн үйл ажиллагаанд ойр, хамтын ажиллагааны байдлаас үүсэлтэй эсэх зэргээс хамааран өөр бусад гуравдагч тал/ханган нийлүүлэгчийн асуудлыг харгалзан авч тусгана. Үүнд дор дурдсан болон бусад асуудлыг</p> |

| Зарчим 1                                 | Байгаль орчноо хамгаалах  |
|--|---|
|  | <p>хамааруулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Харилцагчийн байгаль орчны эрсдэл, нөлөөллийг удирдах чадвар, үүрэг амлалт (үүнд: байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж удирдах, нөөцийг үр ашигтай хэрэглэх асуудлыг системтэй хэрэгжүүлэх чадвартай эсэх, байгалийн нөөцийг хадгалах, нөхөн сэргээх санаачилгатай эсэх).</li> <li>- Харилцагчийн төсөл нь байгаль орчинд нөлөөлөл үзүүлэх бүсэд явагдаж байгаа эсэх, төслийн хэлбэр, цар хүрээ.</li> <li>- Үйл ажиллагаа явагдах байршил (тухайн төсөл нь тусгай хамгаалалттай болон байгаль орчны чухал ач холбогдол бүхий бүсэд хэрэгжиж байгаа эсэх).</li> <li>- Байгалийн ямар нөөцийг, ямар арга (олборлолтын технологи) ашиглан олборлож байгаа, тухайн нөөц нь хязгаарлагдмал эсэх, шинээр гарсан хууль тогтоомжийн улмаас нэмэлт шаардлага, эрсдэл, үр дагавар бий болсон эсэх.</li> </ul>  |
| Сайн туршлагаас                          | <ul style="list-style-type: none"> <li>• Стандарт Чаттерэд (Standard Chartered) банк нь байгаль орчны чиглэлээр анхаарвал зохих бизнесийн 20 салбарыг онцолж, хэрхэн анхаарал хандуулж ажиллахаа тодорхойлсон мэдэгдэлтэй байдаг (Үүнд хөдөө аж ахуй, загасны аж ахуй, дал модны тос, био түлш г.м хамаардаг) (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ANZ банк нь ойн аж ахуй, усны асуудлыг хөндсөн байгаль орчны хамгаалал, тогтвортой байдлын хэд хэдэн бодлого гаргасан (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• “Банкуудад зориулсан биологийн олон янз байдал” хөтөлбөр” /Biodiversity fo Banks Programme/ (<a href="#">Холбоос</a>) нь биологийн олон янз байдлын асуудлуудыг банкнаас дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь банкуудад туслах зорилгоор тусгайлан боловсруулсан лавлах материал, мэдээллийн цахим сан юм.</li> <li>• “Байгалийн баялгийн тунхаг” (<a href="#">Холбоос</a>) /The Natural Capital Declaration/ нь дэлхийн санхүүгийн байгууллагуудаас өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд байгалийн баялагийн үнэлгээний шалгууруудыг нэвтрүүлэх үүрэг амлалтын баримт бичиг юм.</li> <li>• “Экосистем болон биологийн олон янз байдлын эдийн засаг” (TEEB) /The Economics of Ecosystems and Biodiversity/ нь биологийн олон янз байдлын эдийн засгийн үр ашгийг тооцоолоход чиглэсэн дэлхий дахины санаачилга юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• “Дэлхийн банкны усны нөхөрлөл” хөтөлбөр /World Bank Water Partnership Programme/ (<a href="#">Холбоос</a>) нь санхүүжүүлж буй төслүүддээ усны зохистой менежментийн ашиг тусын талаар мэдээлэх зорилготой.</li> </ul> |
| Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд | <p>Банк энэхүү зарчмыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг авна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчинд хохирол учруулахаас зайлсхийсэн, хохирлыг багасгаж, бууруулах нийтлэг хандлагатай тогтвортой санхүүжилт (ToC)-ийн бодлого, үйл ажиллагааны журмыг боловсруулан хэрэгжүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Холбогдох хууль тогтоомж болон олон улсын стандарт, хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг бүрэн дэмжих;</li> <li>• Харилцагч, төслийн үйл ажиллагаанд зээл олгохдоо холбоотой шийдвэр гаргах явц, дью дилиженс үнэлгээний явцад байгаль орчны асуудлыг харгалзах авч үзэх асуудал, шалгуурыг тодорхойлсон байх;</li> <li>• Харилцагчийн үйл ажиллагаанаас байгаль орчин, байгалийн нөөцөд үүсч болзошгүй нөлөөлөл, эдгээр нөлөөллүүдээс банкинд учирч болзошгүй эрсдэлийн талаар ойлголт өгөх зорилгоор банкны холбогдох ажилтнуудад зориулан тусгайлсан сургалт явуулж байх.</li> </ul> </li> <li>• Банкны ажилтнуудыг байгаль орчны эрсдэлийн түвшинг үнэлж, тогтооход нь туслах зааварчилгаа болон практик үйл ажиллагааны мэдээллээр хангах.</li> </ul>   |



| Зарчим 2   | Хүний эрх, нийгмийг хамгаалах   |
|--|---|
| Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана. |   |
| <p>Тайлбар</p> <p>Холбогдох олон улсын стандарт</p>  | <p>Банк нь харилцагч, зээл олгож буй төслийн үйл ажиллагаанаас хувь хүн болон иргэдийн эрх, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл учирч байгаа эсэх, харилцагч нь нийгмийн зохих стандартуудыг мөрдөж байгаа эсэхийг харгалзан авч үзнэ.</p> <p>Хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрхэмлэн, Монгол Улсын хуулиуд, нэгдэн орсон олон улсын гэрээ конвенциудад нийцэж буй хөдөлмөрийн стандартуудыг мөрдөж буй бизнесийн үйл ажиллагааг банк нь боломжоороо дэмжин ажиллана.</p> <p><b>Холбогдох стандарт</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 2 (Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны нөхцөл), 4 (Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон хамгаалалт), 5 (Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн суурьшуулалт), 7 (Нутгийн иргэд) (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Салбар тус бүрийн онцлогийг харгалзан үзсэн хүний эрх, хөдөлмөрийн стандарттай холбоотой мэдээллийг багтаасан ОУСК-ийн Байгаль орчин, Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны удирдамж (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• OHSAS 18001 (Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны тогтолцооны олон улсын стандарт) (<a href="#">Холбоос</a>)</li> </ul> <p><b>Олон улсын тунхаг бичиг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүний эрхийн түгээмэл тунхаглал (НҮБ-ын ХЭХ) (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Нэгдсэн үндэстний байгууллага: НҮБ-ын Хүний эрхийн "Хамгаал, Хүндэл, Сэргээ" зарчмын хэрэгжүүлэлтийн удирдамж /Guiding Principles for the Implementation of the United Nations "Protect, Respect and Remedy" Human Rights Framework/ (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын Ажлын байран дээрх хүний эрх, үндсэн зарчмуудын тунхаг бичиг /Declaration on Fundamental Principles and Rights at Work/ (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Хүний эрх, хамгааллын сайн дурын зарчмууд /The Voluntary Principles on Security and Human Rights/ (<a href="#">Холбоос</a>)</li> </ul> |
| Хэрэгжүүлэлт   | <p>Банк нь өөрийн тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого, журмын хүрээнд харилцагч, зээл олгож буй төслийн үйл ажиллагаа, шаардлагатай тохиолдолд гуравдагч тал/ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн стандартын асуудал, нөлөөлөлд анхаарлаа хандуулсан бодлого, журмыг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй. Харгалзах авч үзэх шаардлагатай асуудалд дор дурдсан болон бусад асуудлыг хамааруулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-д заасан амьд байх эрх, эрх чөлөө, хувийн халдашгүй байдал зэрэг үндсэн эрхүүд зөрчигдөж буй эсэх;</li> <li>• Гарал үүсэл, угсаа, арьсны өнгө, хүйс, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, нийгэмд эзлэх байр суурь, гэр бүлийн байдал, жирэмслэлт, гэр бүлийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, орлого, эд хөрөнгө, шашин шүтлэг, хувийн итгэл үнэмшил, хүний ажиллах чадварт нөлөөлөхгүй бусад хүчин зүйлс дээр суурилсан ялгаварлан гадуурхалт байгаа эсэх;</li> <li>• Хүчээр болон албадан хөдөлмөр эрхлүүлж буй эсэх;</li> <li>• Хүүхдийн хөдөлмөрийн асуудал (хөдөлмөрийн насны доод хязгаарыг тогтоон мөрдүүлэх), хүүхдийн хөдөлмөртэй холбоотой тогтоосон хязгаарлалт бий эсэх (хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахууныг доройтуулах ажил, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэр, шударга бус цалин, хүүхдийн хулгай);</li> <li>• Хөдөлмөрийн гэрээ нь Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцээгүй эсэх;</li> <li>• Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын гэрээ хэлэлцээр хийх эрхийг хязгаарласан эсэх;</li> </ul>   |

| Зарчим 2                                 | Хүний эрх, нийгмийг хамгаалах  |
|--|--|
|  | <ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөрлөх эрхийг хангахтай холбоотой гомдол барагдуулах механизм бий эсэх;</li> <li>• Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг мөрддөг эсэх, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлдөг эсэх;</li> <li>• Шууд болон шууд бус (сэтгэл зүйн) дарамт, бэлгийн дарамтаас ангид эрүүл, аюулгүй хөдөлмөрлөх орчноор хангагдаж байгаа эсэх;</li> <li>• Нийтийн эрхийн зөрчлийг үүсгэсэн эсэх (жишээ нь: албадан нүүлгэн шилжүүлэлт, амьжиргаа, орлогын эх үүсвэрийн өөрчлөлт, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюултай, хортой нөлөөлөл учруулах асуудал).</li> </ul>   |
| Сайн туршлагаас                          | <ul style="list-style-type: none"> <li>• Рабо банкны “Хүний эрхийн бодлого” /Human Rights Policy/-ыг хүний эрхийн талаарх санхүүгийн байгууллагуудын хандлагын тухай үр дүнтэй жишээ гэж үзэж болно. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 2 (Хөдөлмөрийн болон ажлын нөхцөл), 4 (Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалал). (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ОУСК: Өөрийн байгууллагын хөдөлмөрийн стандартуудын гүйцэтгэлийг үнэлж, сайжруулах: Хөдөлмөрийн стандартын талаар практик мэдээлэл олгох Гүйцэтгэлийн стандарт 2-ын Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны нөхцөлийн гарын авлага. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр-Санхүүгийн санаачилга (UNEP-FI)-аас Хүний эрхийн гарын авлагыг боловсруулсан бөгөөд энэ нь санхүүгийн байгууллагуудыг өөрийн бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийн стандартуудыг хэрэгжүүлэхийг дэмжих зорилготой юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Банкуудын Thun Групп: “НҮБ-ын бизнес ба хүний эрхийн зарчмууд” /UN Guiding Principles on Business and Human Rights/-ын 16–21 зарчмуудын ач холбогдлын талаар банкуудад зориулан тэмдэглэл хэвлэн гаргасан. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ОУСК: Санхүүгийн байгууллагуудад үнэлгээ хийхэд нь туслах зорилгоор “Хүний эрхэд үзүүлэх нөлөөлийн үнэлгээний болон менежментийн удирдамж” /Guide to Human Rights Impact Assessment and Management/- ийг боловсруулсан (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ОУСК: “Дотооддоо гэрээ хэлцэл байгуулах үйл ажиллагааны ил тод байдлын тогтолцоог бий болгох нь” /A Transparent System for Local Contracting/ (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Дэлхийн банкны групп: “Дэлхийн банкны группийн хэмжээнд хүний эрхийн асуудлуудыг нэгтгэх арга зам” /A Roadmap for Integrating Human Rights into the World Bank Group/ нь санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхийн асуудлуудыг нэгтгэхтэй холбоотой бэрхшээл, ололтуудын талаар ойлголт өгөх баримт бичиг юм (<a href="#">Холбоос</a>).</li> </ul> |
| Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд | <p>Банк энэхүү зарчмыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг авна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүний эрх, хөдөлмөрийн стандартыг харгалзсан, иргэд, нийгмийг хамгаалах нийтлэг хандлагатай тогтвортой санхүүжилт (ToC)-ийн бодлого, үйл ажиллагааны журмыг боловсруулан хэрэгжүүлэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг бүрэн дэмжих;</li> <li>• Бизнесийн шийдвэр гаргах явц, дью дилиженс үнэлгээний явцад хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн стандартуудыг харгалзах авч үзэх асуудал, шалгуурыг тодорхойлсон байх;</li> <li>• Хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн асуудлын талаар ойлголт өгөх зорилгоор банкны холбогдох ажилтнуудад зориулан гарын авлага бэлтгэж, тусгайлсан сургалт явуулж байх.</li> </ul> </li> <li>• Банкны ажилтнуудыг нийгмийн эрсдэлийн түвшинг үнэлж, тогтооход нь туслах зааварчилгаа болон практик үйл ажиллагааны мэдээллээр хангах.</li> </ul>   |

| Зарчим 3  | Соёлын өвийг хамгаалах  |
|---|---|
| <p>Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.</p> |   |
| <p>Тайлбар</p>  | <p>Банк нь харилцагч, зээл олгож буй төслийн үйл ажиллагаанаас соёлын өвд (Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар<sup>1</sup> биет болон биет бус гэж тодорхойлогдсон соёлын өв) сөрөг нөлөөлөл учирч буй эсэх, холбогдох стандартуудыг мөрдөж буй эсэхийг харгалзан авч үзнэ. Банкууд соёлын өвд хохирол учруулахаас зайлсхийхийн зэрэгцээ үл сэргээдэх шинж чанартай гэмтсэн, алдагдсан ховор нандин соёлын өвийг хадгалан хамгаалж, алдагдсан өвийг эргүүлэн авчрах асуудалд онцлон анхаарлаа хандуулах шаардлагатай. Түүх, соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах аливаа үйл ажиллагааг боломжоороо дэмжин ажиллана.</p> <p>Энэхүү зарчмын хүрээнд тодорхойлогдох соёлын өвийг Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар дараах байдлаар ангилж, соёлын өвтэй холбогдолтой харилцааг зохицуулна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Соёлын биет өв</b> – түүх, соёл, шашны чухал ач холбогдол бүхий археологи, палеонтологийн олдвор, эртний суурин, үлдэгдэл, эд өлгийн зүйлс, урлагийн бүтээл, үл хөдлөх бусад дурсгал (тухайлбал, буган чулуу, хадны сүг зураг, булш бунхан, эртний хот суурин, түүхэн барилга, хөшөө, үнэт чулуу, <u>UNESCO-ийн Дэлхийн өвийн жагсаалтанд бүртгэгдсэн байгаль, соёлын өв газрууд гэх мэт</u>).</li> <li><b>2. Соёлын биет бус өв</b> – үеэс үед дамжин уламжлагдсан ардын уламжлалт арга ухаан, мэдлэг, туршлага уламжлал, ур чадвар, мөн түүх, сэтгэлгээ, зан үйл, архитектор, гоо сайхан, шинжлэх ухааны ач холбогдол бүхий биет бус соёлын өвүүд (тухайлбал, эх хэл, үндэсний бичиг, аман яриа, үлгэр домог, уртын болон богины дуу, хөөмий, ардын бүжиг, уран нугаралт, ёс заншил, баяр ёслол, амьдралын хэв маяг гэх мэт).</li> </ol> <p>Банкууд соёлын өвийг хадгалан хамгаалах зорилготой санхүүгийн үйл ажиллагааг анхаарч үзэх шаардлагатай бөгөөд ингэснээр Монгол Улсад дараах үр ашгийг бий болгох боломжтой:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал/эдийн засгийн шинэ боломж бий болох</li> <li>• Шинээр ажлын байр бий болох</li> <li>• Соёлын өв газарт байрлах үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэх</li> </ul> |
| <p>Холбогдох олон улсын стандартууд</p>   | <ul style="list-style-type: none"> <li>• ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 8 (Соёлын өв) / Гүйцэтгэлийн стандарт 7 (Нутгийн иргэд). (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (НҮББШУСБ)-ын Дэлхийн соёлын өвийн жагсаалт /World Heritage List/ (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци /Convention Concerning the Protection of the World Cultural and Natural Heritage/ (<a href="#">Холбоос</a>)</li> </ul>   |
| <p>Хэрэгжүүлэлт</p>   | <p>Банк нь өөрийн тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого, журмын хүрээнд харилцагч, зээл олгож буй төслийн үйл ажиллагаа, шаардлагатай тохиолдолд гуравдагч тал/ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй соёлын өвийн асуудал, нөлөөлөлд анхаарлаа хандуулсан бодлого, журмыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Харгалзан авч үзэх асуудалд дор дурдсан болон бусад асуудлыг хамааруулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Харилцагч, зээлтэй холбоотой үүсч болох аливаа соёлын өвийн үнэ цэнийг тодорхойлох, үнэлэх, үнэ цэнийг тогтоох асуудал (олборлолт, газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлсний дараа соёлын өв илэрч болох нөхцлийг мөн</li> </ul>  |

<sup>1</sup> <http://www.legalinfo.mn/law/details/455>

| Зарчим 3                                 | Соёлын өвийг хамгаалах   |
|--|--|
| Сайн туршлагаас                          | <p>тооцож үзнэ);</p> <ul style="list-style-type: none"> <li>• Харилцагч, хэрэгжүүлэх төсөлтэй холбоотой соёлын өвийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн эсэх, соёлын өвийн үнэлгээний түвшин;</li> <li>• Тухайн төсөл, харилцагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой биет болон биет бус соёлын өвд материаллаг эвдрэл, сүйтгэл гарахгүй нь баталгаатай эсэх;</li> <li>• Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн, бүртгэгдэхээр судлагдаж буй газар, улсын тусгай хамгаалалттай газарт эвдрэл, сүйтгэл учрах эрсдэл бий эсэхийг тогтоох;</li> <li>• Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн эсэх;</li> <li>• Тухайн харилцагч, төсөлтэй холбогдуулан хамгаалалтад авсан соёлын өвийг олон нийт ашиглах боломжтой эсэх.</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>• Эйч Эс Би Си (HSBC) банкинд “Дэлхийн соёлын өвийн сангийн бодлого” байдаг. /World Heritage Site Policy/ (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 8 (Соёлын өв), 7 (Нутгийн иргэд) (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ОУСК: Орон нутаг дахь стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалт: Хөгжиж буй зах зээлд бизнес эрхэлж байгаа компаниудад зориулсан сайн туршлагын гарын авлага /Strategic Community Investment: A Good Practice Handbook for Companies Doing Business in Emerging Markets/ (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ОУСК: Хүмүүст оруулах хөрөнгө оруулалт: Бизнесийн туршлагыг сайжруулах замаар орон нутгийн тогтвортой хөгжилд хүрэх /Investing in People: Sustaining Communities Through Improved Business Practice/ (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ДБНИ /WRI/: <b>Анхны алхам хийх:</b> Орон нутгийн иргэдийг олборлох үйлдвэрлэл, дэд бүтцийн төслүүдэд татан оролцуулах нь. (<b>Breaking Ground: Engaging Communities in Extractive and Infrastructure Projects</b>) (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• НҮБ-ын Нутгийн иргэдийн эрхийн тунхаглал /UN Declaration on the Rights of Indigenous People/ (<a href="#">Холбоос</a>)</li> </ul> |
| Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд | <p>Банк энэхүү зарчмыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг авна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Соёлын өвийн дараах асуудлуудад анхаарлаа хандуулсан тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого, үйл ажиллагааны журмыг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Соёлын өвийг хадгалах, хамгаалах зорилготой холбогдсон хууль тогтоомж, олон улсын стандарт, хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг бүрэн дэмжих;</li> <li>• Бизнесийн шийдвэр гаргах явц, дью дилиженс үнэлгээний явцад соёлын өвийг харгалзах авч үзэх асуудал, шалгуурыг тодорхойлсон байх (олон нийттэй хийх хэлэлцүүлгийн шаардлагын удирдамжийг багтаасан);</li> <li>• Соёлын өвийн асуудлаар ойлголт өгөх зорилгоор банкны холбогдох ажилтнуудад зориулан гарын авлага бэлтгэж, тусгайлсан сургалт явуулж байх.</li> </ul> </li> <li>• Банкны ажилтнуудыг соёлын өвийн эрсдэлийн түвшинг үнэлж, тогтоох, түүнчлэн болзошгүй эрсдэлийн удирдлагын шийдлийг тодорхойлоход нь туслах зааварчилгаа болон практик үйл ажиллагааны мэдээллээр хангах.</li> </ul>   |

| Зарчим 4  | “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих  |
|---|---|
| Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл, бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана. |   |
| <p>Тайлбар</p> <p>Холбогдох олон улсын стандартууд</p> <p>Хэрэгжүүлэлт</p>                                  | <p>“НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөрөөс байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг “Ногоон эдийн засаг” гэж тодорхойлсон. Дэлхийн банкны тодорхойлсноор “Ногоон өсөлт” нь байгалийн нөөцийн үр ашигтай хэрэглээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бохирдлыг багасгах цэвэрлэгээ, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны удирдлага, байгалийн нөөцийн үүрэг хариуцлагыг харгалзан авч үзэх уян хатан байдал бүхий байгаль орчны хувьд тогтвортой өсөлт юм.</p> <p>Банкууд сэргээгдэх, цэвэр эрчим хүч, байгалийн нөөцийн үр ашигтай ашиглалт, цэвэр үйлдвэрлэл, хийн хаягдлыг бууруулсан, хог хаягдлын сайжруулсан удирдлагатай төсөл, ногоон эдийн засгийн өсөлт, хөгжлийг идэвхтэй дэмжсэн бусад үйл ажиллагаа бүхий төслийг дэмжиж санхүүжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх нь зүйтэй юм. Энэ нь хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, Монгол хүний эрүүл, сайн сайхан байх нөхцөлийг сайжруулах арга зам болж чадна. Банк нь үйл ажиллагаагаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монгол банкнаас баримталж буй ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих стратегид нийцүүлэхийг эрмэлзэн явуулна.</p> <p>Банк нь харилцагчийн үйл ажиллагаа шавхагдаж буй нөөцөөс хамааралтай эсэх, харилцагчийн үйл ажиллагаа илүү цэвэр, үр ашигтай, ногоон технологи ашигласнаар сайжрах боломжтой эсэхийг анхаарч үзэх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• ISO 50001 2011 нь зах зээл дээр борлуулагдаж буй нэг төрлийн эрчим хүчний удирдлагын тогтолцоо юм. <a href="#">(Холбоос)</a></li> <li>• ISO 21929-1 2011 нь шинэ, хуучин байрны загвар, бүтэц, засвар, барилгын явц, өнгөлгөө, барилгын ашиглалтын дуусах хугацаатай холбоотой тогтвортой байдлын талаарх багц үзүүлэлт юм. <a href="#">(Холбоос)</a></li> <li>• Хүлэмжийн хийн протоколын санаачлага /The Greenhouse Gas Protocol Initiative/ нь банкны харилцагч нарт өөрийн байгууллагын хүлэмжийн хийн ялгаруулалтыг зохицуулахад зориулсан стандарт аргачлалын тухай баримт бичиг юм. <a href="#">(Холбоос)</a></li> <li>• АНУ-ын Ногоон байгууламж зөвлөлийн Эрчим хүч, байгаль орчинд ээлтэйг гэрчилгээжүүлэх институт /U.S. Green Building Council Green Building Certification Institute / – Existing Building нь олон улсын ногоон байгууламжийн гэрчилгээ олгодог хөтөлбөр бөгөөд барилга байгууламжийн төсөл загвар, барилгын ажил, ашиглалт, засвар үйлчилгээний үед хэрэгжүүлж болох арга хэмжээний мэдээллээр хангадаг. <a href="#">(Холбоос)</a></li> <li>• Байгаль хамгааллын агентлагийн Энержи стар хөтөлбөр /EPA Energy Star/ нь эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан төхөөрөмж, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, барилга байгууламжийн эрчим хүчний бодлогын олон улсын жишиг тогтоох судалгааг санал болгодог. <a href="#">(Холбоос)</a></li> <li>• Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэн /The International Institute for Sustainable Development/ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд сайн дурын тогтвортой хөгжлийн стандартыг нэвтрүүлэхэд хувийн хэвшлийн оролцооны талаар тайланг хэвлүүлсэн. <a href="#">(Холбоос)</a></li> </ul> <p>Банк нь өөрийн тогтвортой санхүүжилт (ToC)-ийн бодлого, журмын хүрээнд харилцагч, шаардлагатай тохиолдолд гуравдагч тал/ ханган нийлүүлэгчээс бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулахад туслахуйц ногоон эдийн засгийн асуудлыг тусгасан үйл ажиллагааны стратегийг боловсруулан хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй. Энэхүү харгалзах асуудалд дор дурдсан болон бусад асуудлыг хамааруулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч, ус, байгалийн бусад нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх шинэ</li> </ul> |



| Зарчим 4           | “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих  |
|--------------------|---|
|                    | <p>технологи, төхөөрөмж (тухайлбал, түүхий эдийн ашиглалтыг нэмэгдүүлэх, байгалийн нөөцийн ашиглалтыг сайжруулах гэх мэт);</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нүүрс хүчлийн давхар исэл, тоос буюу агаар дахь бусад бохирдуулагчийн хэмжээг бууруулах;</li> <li>• Үр ашигтай, хаягдал бага гаргадаг цэвэр үйлдвэрлэл, үйлчилгээний аргыг ашиглах;</li> <li>• Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалт, түүхий эд;</li> <li>• Сэргээгдэх эрчим хүчний ашиглалт (жишээлбэл, нар, салхи, усан цахилгаан ба газрын гүний дулааны ашиглалт гэх мэт);</li> <li>• Ажлын орчин ба эрүүл ахуйн, аюулгүй ажиллагааны нөхцөлийг сайжруулахуйц технологи, аргачлал.</li> </ul> <p>Банк нь өөрийн үндсэн үйл ажиллагаа, үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнчлэн “ногоон” бүтээгдэхүүн, үйлчилгээг зохих байдлаар хөгжүүлэх зах зээлийн шинэ боломжийг судалсаны үндсэн дээр өөрийн ногоон эдийн засгийг дэмжих арга барилыг боловсруулах шаардлагатай. Үүнээс гадна харилцагчийг “илүү ногоон” үйл ажиллагаа явуулснаар олох бизнесийн ашиг орлогын талаар ойлголттой болоход нь дэмжиж, мэдээлэл олгох тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p>Банкнаас авч хэрэгжүүлж болохуйц “ногоон” бүтээгдэхүүн, үйлчилгээний зарим жишээг доор тусгав:</p> <p><u>Иргэдийн банк</u> – Ногоон кредит/дебит карт; ногоон хадгаламжийн данс; ногоон зээлийн тогтолцоо; ногоон моргейж;</p> <p><u>Жижиг дунд үйлдвэрлэл ба байгууллагын банк</u> – капиталын хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг ногоон/нийгмийн хариуцлагатай зээлд зориулах; байгууллагын үл хөдлөх хөрөнгийн ногоон лизинг, байгаль орчны тэргүүлэх туршлагуудын талаар зөвлөгөө өгөх;</p> <p><u>Төслийн санхүүжилт</u> – байгаль орчинд эерэг нөлөөлөл үзүүлж, байгаль орчны менежментийн чадавхи сайтай гэдгээ харуулах төслийн санхүүжилтийг дэмжих; дэвшилтэт, сэргээгдэх технологийг ашиглаж буй шинэ төсөлд санхүүгийн шинэ боломжийг олгож, дэмжих;</p> <p><u>Хөрөнгө оруулалтын банк</u> –Хөрөнгө оруулалтын багц нь байгаль орчин, нийгмийн хариуцлагатай харилцагч, төсөлд чиглэх; хүлэмжийн хийг бууруулах шагнал урамшуулал, санхүүжилтийн төлөвлөгөөг боловсруулах; ногоон бонд гаргах.</p> |
| Тэргүүн туршлагаас | <ul style="list-style-type: none"> <li>• Хас банкны Иргэдийн Эко банкны хэлтсээс хэд хэдэн үйлчилгээг санал болгодог бөгөөд үүнд: Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой моргейжийн зээл, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 20% бууруулах зорилготой жижиг, дунд бизнесийн зээл, мөн утаагүй зуух худалдан авахад зориулсан эко-зээл зэрэг бүтээгдэхүүнийг дурдаж болно. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Стандарт банк нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх санхүүжилттэй холбоотой хэд хэдэн байгаль орчны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлдэг. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Нидерландад төвтэй Триодос банкны бүх үйл ажиллагаа нь Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн хүрээнд явагддаг бөгөөд маш олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• NEFCO бол олон улсын санхүүгийн байгууллага бөгөөд голчлон Орос, Украин, Эстони, Латви, Литви, Молдав ба Беларусст хөрөнгө оруулалт хийж, төсөл санхүүжүүлэхийн зэрэгцээ дэлхийн олон орны уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх төслүүдэд санхүүжилт олгодог. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Сэргээгдэх эрчим хүчний Барклэс Баг /Barclays Renewable Energy Team/: Сэргээгдэх эрчим хүчний тал дээр тууштай үйл ажиллагаа явуулдаг энэхүү баг нь тухайн салбарт тохирсон үнэлгээ хийх үйлчилгээг санал болгодог. Энэ нь фермер ба газар өмчлөгч нарт салхи, ус, нарны эрчим хүч ашиглах, хүчилтөрөгчгүй орчинд задрал явуулах зэрэг сэргээгдэх эрчим хүчний төслийг хэрэгжүүлэхэд нь санхүүжилт олгоход төвлөрч ажилладаг. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан RBS-н эрчим хүчний хэмнэлтийн зээлийн сан: Тус сангийн дэргэд эрчим хүчний аудитын хөтөлбөр давхар хэрэгждэг</li> </ul>   |

| Зарчим 4                                 | “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих   |
|--|--|
|  | <p>бөгөөд энэ нь өөрсдийн бизнесийг илүү ногоон болгохыг эрмэлзэж буй жижиг, дунд үйлдвэрлэлд тусалдаг. Энэ зээл нь дулааны тусгаарлалт, гэрэлтүүлэг, байгаль орчинд ээлтэй шинэ уурын зуух зэрэг эрчим хүч хэмнэх арга хэмжээнд шаардлагатай зардалыг төлөхөд зориулагддаг. <a href="#">(Холбоос)</a></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нүүрстөрөгч ялгаруулалтыг нийтэд ил тод болгох төсөл (Carbon Disclosure Project): Энэ нь тодорхой төрлийн үйл ажиллагааны нөлөөллийг хэмжин, тайлагнаж, мэдээлэл түгээх систем бөгөөд байгаль орчны мэдээлэлтэй холбоотой бодлогыг олж авах олон улсын мэдээллийн эх сурвалж юм. <a href="#">(Холбоос)</a></li> </ul>  |
| Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд | <p>Банк энэхүү зарчмыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг авна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ногоон эдийн засгийн асуудалд анхаарлаа хандуулсан бизнес, үйл ажиллагааны стратегийг боловсруулж хэрэгжүүлэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Банкны үндсэн үйл ажиллагаа ба хөгжлийн зорилтод ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний дараах асуудал тусгагдсан эсэхийг харгалзана авч үзнэ: <ul style="list-style-type: none"> <li>• Бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрт тохирсон аливаа хөнгөлөлт, нэмэлт урамшуулал ба бусад хөшүүрэг, харилцагчид бий болох бусад давуу тал;</li> <li>• Монгол банкнаас хийж буй аливаа зохицуулалт, хөнгөлөлт, ногоон хөшүүргийг даган мөрдөх;</li> <li>• Монгол Улсын банкны салбар, Монгол банк, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон стратеги хөгжлийн тодорхой хөтөлбөрт хамрагдах.</li> </ul> </li> <li>• Санхүүжилт нь шаардлага хангахуйц харилцагч, төсөлд хүрч буйг баталгаажуулах үүднээс зээл олгох шийдвэр гаргах үйл ажиллагаа ба дью дилижинс үнэлгээнд тодорхой асуудал, шалгууруудыг харгалзан авч үзнэ;</li> <li>• Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар ойлголт өгөх зорилгоор банкны холбогдох ажилтнуудад зориулан тусгайлсан сургалт явуулах, гарын авлага бэлтгэх.</li> </ul> </li> <li>• Банкны ажилтнуудаас банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд нь туслах зааварчилгаа болон практик үйл ажиллагааны мэдээллээр хангах.</li> </ul> |

| Зарчим 5   | Санхүүгийн хүртээмжийг дэмжих  |
|--|--|
| <p>Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, харилцагч хамгаалагдах баталгааг бий болгох замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.</p> |  |
| <p>Тайлбар</p> <p>Холбогдох олон улсын стандартууд</p>   | <p>Монгол Улсын нийгмийн зарим хэсэг нь тодорхой шалтгаан (тогтмол бус орлого, ажилгүйдэл, санхүүгийн мэдлэг дутмаг байдал, банкны үйлчилгээ авах боломжгүй байдал, үйлчилгээний өндөр өртөг, оновчгүй бүтээгдэхүүн үйлчилгээ, хууль эрх зүйн хязгаарлалттай байдал, санхүүгийн байгууллагад итгэх итгэл сул зэрэг)-ны улмаас санхүүгийн үйлчилгээ хүртэх боломжоор хязгаарлагдмал байна.</p> <p>Банк өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ амьдралын боломж муутай, үйлчилгээ хязгаарлагдмал хэсэгт хүрч байгаа эсэх, мөн харилцагчийг мэдээллээр хангах, тэдгээрт зориулагдсан тусгай үйлчилгээ, хамгаалах арга хэмжээ бэлэн байгаа эсэхийг харгалзаж үзэх шаардлагатай. Хэрэв ямар нэг шийдвэрлэгдээгүй асуудал байгааг олж мэдсэн тохиолдолд банкнаас өөрийн харилцагч болон олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох асуудлыг өргөн хүрээтэйгээр сургалтын зохистой аргачлал, нөөцийг ашиглан явуулж, тэдгээрт санал болгож буй бүтээгдэхүүнийг сайжруулах, хүргэхийг идэвхийлэн эрэлхийлэх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн хүртээмжийн дэлхийн түншлэл /Global Partnership for Financial Inclusion/ нь Их 20-ын орнуудын Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн шалгуурыг боловсруулсан байна (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Санхүүгийн хүртээмжийн эвсэл /The Alliance for Financial Inclusion/ нь хөгжиж буй орны санхүүгийн бодлого боловсруулагчидтай ядуу иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг зохих түвшинд нэмэгдүүлэх тал дээр хамтран ажилладаг дэлхийн хэмжээний сүлжээ юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Маяагийн тунхаглал /The Maya Declaration/ бол санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хэмжих олон улсын үүрэг амлалтын анхны багц /одоогоор хөгжиж буй орнуудын банкинд хийгээгүй байгаа/ юм. (<a href="#">Холбоос</a>)</li> </ul> |
| <p>Хэрэгжүүлэлт</p>  | <p>Банк нь өөрийн Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого, үйл ажиллагааны журмын хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ шинэчлэн боловсруулах, төрөлжүүлэх, шинэ зах зээл, шинэ салбарт хүргэхийн зэрэгцээ иргэд, харилцагчдийн санхүүгийн мэдлэг, боловсролыг нэмэгдүүлж, эмзэг бүлгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ (тухайлбал, зээлдэгч илт хохиролтой зээлээс зайлсхийх, харилцагч нь зохих бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж буй эсэхийг баталгаажуулах)-г багтаасан санхүүгийн хүртээмжийн стратегийг боловсруулна.</p> <p>Банк нь санхүүгийн хүртээмжийн стратегийг боловсруулахдаа дараах асуудлыг анхаарч үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсад санхүүгийн үйлчилгээ авах хязгаарлагдмал бүлгийн санхүүгийн үйлчилгээ хүртэхэд тулгарч болж буй өнөөгийн бэрхшээл (Тухайлбал санхүүгийн мэдлэггүй байх, салбарын байршил, данс нээхэд тавигдах шаардлага гэх мэт).</li> <li>• Банкны үндсэн үйлчилгээний стратеги, санхүүгийн хүртээмж хязгаарлагдмал иргэдэд үзүүлэх боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс шалтгаалж тэдгээр нь “зорилтот” байдлаар банкны үйлчилгээг хүртэж буй эсэхийг баталгаажуулна.</li> </ul> <p>Банк нь дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд үүсч болзошгүй бэрхшээлийг тодорхойлж, тодорхой зорилтот зах зээл, өөрийн банкны үндсэн бизнесийн загварт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсруулах;</li> <li>• Жижиг, дунд бизнес эрхлэгчид, бусад цөөнх буюу тусгаарлагдсан нийгмийн бүлэгт зориулж тодорхой дэмжлэг үзүүлэх;</li> </ul>  |



| Зарчим 5                                 | Санхүүгийн хүртээмжийг дэмжих   |
|--|---|
|  | <ul style="list-style-type: none"> <li>• Харилцагчдад санхүүгийн мэдлэг олгох, энэ төрлийн практик үйл ажиллагааг өргөжүүлэх механизм, чадавхижуулах арга замыг боловсронгуй болгох;</li> <li>• Банкнаас үйлчилгээгээ хүргэхдээ хэрэглэж буй аргачлал, тоног төхөөрөмжийг ашиглах боломж (тухайлбал банкны үйлчилгээний цагийн хуваарийг уян хатан болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх, цахим үйлчилгээ гэх мэт)-ийг нэмэгдүүлж, шаардлагатай тохиолдолд шинэ технологийг нэвтрүүлэх (тухайлбал мобайл банк гэх мэт).</li> </ul>  |
| Сайн туршлагаас                          | <ul style="list-style-type: none"> <li>• “Mobile Banking – Дэлхийн банкнаас мобайл банкныг Кени улсад амжилттай нэвтрүүлсэн туршлага байдаг”. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Энэтхэг улсын YES банкинд бичил, жижиг, дунд банкны үйлчилгээ үзүүлэх хэлтэс байдаг. Энэ баг нь зорилтот бүлгүүдэд чиглэсэн хувийн банкны үйлчилгээг үзүүлдэг (жишээ нь эмэгтэйчүүд). (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ОУСК нь саяхан Азийн болон бусад хөгжиж буй зах зээлийн шилдэг туршлагын талаар бичсэн “Нөлөөллийн түүх: Санхүүгийн хүртээмж” /Stories of Impact: Financial Inclusion/ хэвлэлийг нийтлүүлсэн. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Харилцагчийг хамгаалах Дэлхийн банкны сайн туршлага /World Bank Good Practices for Financial Consumer Protection/ нь харилцагчийг хамгаалах сайн механизмыг боловсруулах тухай тойм баримт бичиг юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Ядуучуудад туслах зөвлөх үйлчилгээний баг, Микрофайнанс Гэйтвэй /CGAP, The Microfinance Gateway/: энэ нь бичил санхүүгийн чиглэлээр гаргасан бодлого болон бодит амьдралын мэдээлэл, судалгааны олон улсын эх сурвалж юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Санхүүгийн хүртээмжийн дэлхийн түншлэл /Global Partnership for Financial Inclusion/: стандарт, мэдээлэл ба эх сурвалжийн баримт бичиг. Эндээс Санхүүгийн хүртээмжийн санаачлагын зарчмууд, Эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмжийг дэмжих зааварчилгаа зэргийг үзэх боломжтой. Санхүүгийн хүртээмжийн дэлхийн түншлэл нь Их 20-ын орнууд санхүүгийн хүртээмжийн болон санхүүжилтийн ажлын төлөвлөгөөний хэрэгжүүлэлтийн механизмын суурь баримт бичиг юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• МЕНА-н жижиг, дунд үйлдвэрлэл /Small and Medium Enterprises in MENA/: Тогтвортой хөгжлийн төлөө хөгжлийн санхүүжилтийн хөшүүрэг. Халид Ал-Яахиа болон Жэннифер Эйрэй нарын хийсэн тогтвортой хөгжлийн хэрэгцээний үр дүн, шинжилгээ. Зүрх сэтгэл, оюун санааны стратеги судлалын зөвлөх компаниас авах боломжтой. (<a href="#">Холбоос</a>)</li> </ul> |
| Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд | <p>Банк энэхүү зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, харилцагчийг зохистой байдлаар хамгаалахад чиглэсэн санхүүгийн хүртээмжийн асуудлыг тусгасан бизнес стратегийг боловсруулж хэрэгжүүлнэ. Үүнд дараах асуудлыг харгалзсан байна: <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн хүртээмжийн асуудал банкны нийтлэг зорилго, бизнесийн үйл ажиллагаатай хэрхэн нийцэж буйг тодорхойлохдоо дараах асуудлыг харгалзан тусгана: <ul style="list-style-type: none"> <li>• Банк нь амьдралын бололцоо муу, үйлчилгээ хүрдэггүй зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ түлхүү хүргэхийг зорих шаардлагатай;</li> <li>• Бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрт тохирсон хөнгөлөлт, нэмэгдэл урамшуулал ба бусад хөшүүрэг, харилцагчийн хүртэх үр ашиг;</li> <li>• Зорилтот харилцагчдыг хамгаалах арга хэмжээ авагдаж буйг баталгаажуулах;</li> <li>• Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх санаачлага болон шалгуурууд.</li> </ul> </li> <li>• Тодорхойлсон харилцагч, төсөлд санхүүжилт нь хүрч буйг баталгаажуулах үүднээс бизнесийн шийдвэр гаргах үйл ажиллагаа ба дью дилиженс үнэлгээнд тусгай асуудал, шалгуурыг тусгана.</li> <li>• Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх стратеги, бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн боловсрол олгох, хамгаалалтын арга хэмжээний талаар банкны холбогдох ажилтнуудад ойлголт өгөхөд зориулан тусгайлсан сургалт явуулах;</li> </ul> </li> </ul>  |

| <b>Зарчим 5</b> | <b>Санхүүгийн хүртээмжийг дэмжих</b>  |
|-----------------|---|
|                 | <ul style="list-style-type: none"><li>• Банкны ажилтнуудыг бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүгийн хүртээмжийн бодлогыг хэрэгжүүлэхэд нь туслах зааварчилгаа, практик үйл ажиллагааны мэдээллээр хангах.</li></ul> |

| Зарчим 6   | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих   |
|--|---|
| <p>Бид хориглосон жагсаалтанд багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн түршлагыг дэмжих бодлого баримтлан ажиллана.</p> |   |
| Тайлбар  | <p>Банк нь батлагдсан “Санхүүжүүлэхийг хориглосон болон анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагааны жагсаалт”-д (Хавсралт 1-г үзнэ үү) хамаарах үйл ажиллагаа болон өндөр эрсдэлтэй зарим үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй. Банкнаас байгаль орчин, нийгмийн нэмэлт дью дилиженс үнэлгээг хийж гүйцэтгэнэ.</p> <p>Банк нь хээл хахууль, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг үл тэвчих бодлого баримталж буйгаа баталж, харилцагчийг мөнгө угаах болон авлигын гэмт хэрэг гаргуулахгүй байх эрсдэлийн удирдлагын тогтолцоо, арга хэмжээг бүрдүүлж байх шаардлагатай. Банк нь ёс зүйтэй дадлыг төлөвшүүлэх, харилцагчид хамаарах компанийн засаглалын механизмыг байнга боловсронгуй болгож дэмжин ажиллах шаардлагатай.</p> <p>Банк нь компанийн засаглал, ёс зүйн хувьд өндөр хариуцлагатай, чадавхитай, ололт амжилтыг бий болгосон (компанийн бодлого, ёс зүйн дүрэм, санал гомдлыг барагдуулах механизм, шударга өрсөлдөөнийг дэмжсэнээ /Монгол Улсын Өрсөлдөөний тухай хуулийг үзнэ үү<sup>2</sup>/ нотлох баримт бичигтэй байх) харилцагчийг санхүүжүүлэхийг зорино. Банк нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль<sup>3</sup>, бусад холбоотой хууль, мөн түүнчлэн Монгол Улсын банкны салбарын үйл ажиллагааг зохицуулж буй журмыг зөрчин авлига, шударга бус өрсөлдөөнтэй холбоотой гэмт хэрэгт холбогдсон аливаа харилцагчийн үйл ажиллагааг бодлогоор санхүүжүүлэхээс татгалзах ёстой.</p>  |
| Холбогдох олон улсын стандартууд   | <ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /The Financial Action Task Force/ (<a href="#">Холбоос</a>) нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон олон улсын санхүүгийн тогтолцооны бүрэн бүтэн байдалд аюул учруулах үйлдэлтэй тэмцэх хууль эрх зүйн, зохицуулалт, үйл ажиллагааны үр дүнтэй хэрэгжилтийг дэмжих стандартыг боловсруулсан.</li> <li>• Их Британийн Хээл хахууль, Авлигын тухай /UK Bribery and Corruption Act/ 2010 оны хууль нь дэлхийд хээл хахуул, авлигатай тэмцэх тэргүүлэх бодлогын баримт бичигт тооцогддог. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг: Зэвсэг ба олон улсын хүмүүнлэгийн тухай хууль. Олон улсын хуулиар хориглосон зэвсгийн, тухайлбал бүү зэвсэг, тэсрэх бөмбөг ба хими, биологийн зэвсгийн талаарх мэдээллийн эх сурвалж. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• CITES (Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай конвенци). Энэ нь зэрлэг амьтан, ургамлын зүйлийг олон улсад худалдаалах харилцааг зохицуулсан олон талт гэрээ юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Вольфсбергийн зарчмууд (харилцагчаа таньж мэдэх, мөнгө угаах үйл ажиллагаа ба терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого). (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Транспаренси Интернейшнл байгууллага– авлигын хор уршгийг олон нийтэд ил тод болгох, таниулах, авлигыг таслан зогсоох талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар олон улсын шилдэг түршлагын мэдээллээр хангана. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Роттердамын конвенци (<a href="#">Холбоос</a>) ба Стокгольмын конвенци (<a href="#">Холбоос</a>) нь тус тус олон улсад ашиглахыг хориглосон химийн бодисын жагсаалтыг баталсан.</li> </ul> |
| Хэрэгжүүлэлт   | <p>Банк нь өөрийн тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого, журмын хүрээнд өөрийн харилцагч, түүний төслийг хориотой, гэмт хэргийн шинжтэй, зөвшөөрөгдөөгүй, маргаантай үйл ажиллагаа эсэхийг нягтлан шалгаж, хууль тогтоомжид нийцэж байгааг баталгаажуулж байх бодлого, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай (Хавсралт 1-г үзнэ үү).</p>   |

<sup>2</sup> <http://www.legalinfo.mn/law/details/12?lawid=12>

<sup>3</sup> <http://www.legalinfo.mn/law/details/9242?lawid=9242>

| Зарчим 6                                 | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих  |
|--|--|
|  | <p>Банк нь өөрийн үндсэн үйл ажиллагаанд ёс зүйтэй санхүүжилт болон компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх ерөнхий бодлогыг боловсруулах шаардлагатай бөгөөд дараах асуудлыг тусгасан байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүжүүлэхийг хориглосон болон анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагааны жагсаалтыг шинэ харилцагч, зээлийг шалгах/зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохицуулалт;</li> <li>• Банкнаас дотооддоо шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжих зохих засаглалын бүтцийг бий болгох (тухайлбал, үнэлэх/зөвшөөрөл авах шалгуур, аудитын журам гэх мэт);</li> <li>• Ёс зүйгүй, гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан тохиолдолд асуудлыг шалгуулах механизм;</li> <li>• Харилцагч, түүний төслийг үнэлэхэд компанийн засаглалын асуудлыг нэгтгэн харгалзан үзэж, харилцагч дараах шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана: <ul style="list-style-type: none"> <li>• Удирдах болон гүйцэтгэх ажилтнуудад засаглалын асуудлыг зохицуулахад нь туслах засаглалын бодлого, ёс зүй, сахилгын дүрэм /авлига, мөнгө угаахтай тэмцэх асуудлыг агуулсан/, түүнчлэн хөндлөнгийн аудитын журамтай байх;</li> <li>• Авлига, гэмт хэргийн шинжтэй үйлдэл зэрэг олон нийт, ажилтнуудын асуудлыг шийдэх, мэдээлэгчийн ашиг сонирхлыг хамгаалсан гомдол барагдуулах механизм байх;</li> <li>• Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой маргаантай байгаа, авлигатай тэмцэх болон Өрсөлдөөний тухай хууль зөрчиж хууль бус үйлдэл гаргасны улмаас эрх зүйн маргаан үүссэн, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явагдаж байгаа эсэх.</li> </ul> </li> </ul> |
| Сайн туршлагаас                          | <ul style="list-style-type: none"> <li>• НҮБ-н Байгаль орчныг хамгаалах хөтөлбөрийн Цогц засаглалын тухай Санхүүжилтийн санаачлагын тайлан: Тогтвортой байдлын төлөөх засаглалын шинэ загвар (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ОУСК-ийн Вьетнам, Хятад болон Зүүн өмнөд Азид хэрэгжүүлж буй компанийн засаглалын төсөл нь үнэлгээний арга, шилдэг туршлагын тайлан бүхий хэрэгтэй мэдээллээр хангадаг. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Рабобанкны авлигын эсрэг тунхаг (<a href="#">Холбоос</a>), Зэвсэгт хүчний бодлого (<a href="#">Холбоос</a>) мөн түүнчлэн Хувирсан амьд организм ба амьтан хамгаалахтай холбоотой маргаантай асуудлын талаар баримтлах байр суурь. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• HSBC банк нь Ойн аж ахуйн бодлогондоо санхүүжүүлэх болон санхүүжүүлэхгүй үйл ажиллагааг тодорхой зааж өгдөг. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ANZ-н цэргийн зориулалттай тоног төхөөрөмжийн бодлого /ANZ Military Equipment Policy/ нь цэргийн зориулалттай ямар төхөөрөмжийг санхүүжүүлэхгүй вэ гэдгийн тодорхой жишээ юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Данске Банкны анхан шатны үнэлгээний удирдамж. /Danske Bank Screening guideline/ Энэхүү баримт бичиг нь Данийн банкны анхан шатны үнэлгээндээ ашигладаг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, стандартын жагсаалтын хэрэгтэй мэдээллийн эх сурвалж юм. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• ABN AMRO-н хүлээн зөвшөөрөх болон үл хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг тодотгосон Батлан хамгаалах ба бусад салбарын бодлого. (<a href="#">Холбоос</a>)</li> </ul>  |
| Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд | <p>Банк энэхүү зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дараахийг агуулсан ёс зүйтэй санхүүжилт болон компанийн засаглалын бодлогыг боловсруулах шаардлагатай: <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүжүүлэхийг хориглосон болон анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагааны жагсаалтыг тодорхой гаргаж санхүүжүүлэхгүй байх, банк болон өөрийн харилцагчийн дагаж мөрдөх компанийн засаглалын суурь удирдамжийг гаргах;</li> <li>• Дью дилиженс үнэлгээний нэг хэсэг болгож санхүүжүүлэхийг хориглосон болон анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагааг шинэ харилцагч, төслийн анхан шатны үнэлгээ хийх журманд нэгтгэн</li> </ul> </li> </ul>  |

| Зарчим 6 | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих   |
|----------|---|
|          | <p>оруулна;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүжүүлэхийг хориглосон болон анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагаа, түүнчлэн компанийн сайн засаглалын гүйцэтгэл хариуцсан хүний нөөц, ажилтныг сургахад хөрөнгө гаргах;</li> <li>• Эрсдэлийн хороонд зориулж гүйцэтгэлтэй холбоотой аливаа урамшуулал, дотоод, гадаад аудитын шаардлага, засаглалын хариуцлага, үнэлгээний шалгуурыг тогтоох.</li> <li>• Байгууллагын ёс зүй, компанийн засаглалын хороог үүсгэн байгуулах;</li> <li>• Компанийн засаглалын асуудал, ялангуяа эрсдэлтэй салбарт үйл ажиллагаа эрхэлж буй харилцагчийн асуудалд анхаарлаа хандуулсан салбарын санаачлагыг идэвхитэй дэмжих.</li> </ul> |

| Зарчим 7  | Ил тод байдал, хариуцлагыг дэмжих   |
|---|---|
| Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана. |   |
| Тайлбар   | <p>Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудыг хэрэгжүүлэхдээ банк нь харилцагчийн нууцыг хадгалахын зэрэгцээ, түүний байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийн явцыг нотолгоотой, ил тод, хариуцлагатайгаар тусгаж тайлагнаж байх шаардлагатай.</p> <p>Банк нь байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлтэй холбоотой салбарын хамтын ажиллагааг идэвхитэй дэмжиж, тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн талаар Монгол Улсад нэгдсэн ойлголт бий болоход туслах зорилготой мэдлэг, сайн туршлагыг хуваалцах үйл ажиллагааг байнга дэмжих шаардлагатай.</p>  |
| Холбогдох олон улсын стандартууд  | <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн салбарт зориулсан Даяар тайлагнах санаачлагын удирдамж /GRI Guidelines for financial sector/ нь банкны дотоодын үйл ажиллагаанд тусгайлан зориулсан, тогтвортой байдлын асуудлуудын тайлагналын сайн туршлагыг онцолсон баримт бичиг (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Даяар тайлагнах санаачлагын олон улсын Тайлагналын удирдамж /GRI International Reporting Guidelines/ G4 нь тогтвортой байдлын тайлагналын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн сүүлийн үеийн сайн туршлага юм. Өөр салбарын нэмэлт өөрчлөлтүүдийг харилцагчийн ил тод байдал, хариуцлагатай байдлыг үнэлэхдээ ашиглах боломжтой. (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• Акойнтабилити /AccountAbility/ нь компанийн засаглалын хариуцлага, тогтвортой хөгжлийг харуулах зорилгоор бизнесийн хариуцлагын багц стандартыг (AA1000 Зарчмууд) боловсруулсан (<a href="#">Холбоос</a>)</li> </ul>   |
| Хэрэгжүүлэлт  | <p>Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлого, журмын хүрээнд банк нь зарчим тус бүрээр өөрийн гүйцэтгэлийг тогтмол үнэлэн хянаж, холбогдох дотоод, гадаад оролцогч талуудад зарчмын хэрэгжүүлэлтийн явцыг тайлагнана. Зарчмын дотоод тайлагналын механизм нь банкны зээл олгох шийдвэр гаргах үйл ажиллагаанд нийцэж, цогц болсон байх шаардлагатай.</p> <p>Банк нь уг зарчмыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг авна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчим тус бүрийн хэрэгжилтийн явцыг тайлагнах;</li> <li>• Тодорхой зорилго, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхой гаргаж, жил жилээр гүйцэтгэлийн үйл явцыг харуулсан мэдээллийг тусгах (тухайлбал: үнэлгээ хийгдсэн харилцагч/төсөл, сургагдсан ажилтан гэх мэт);</li> <li>• Шаардлагатай бодлого, журмыг банкны зээл олгох зөвшөөрөл, эрсдэлийн үнэлгээ, засаглалын тогтолцоонд нэгтгэн тусгах;</li> <li>• Зохих мэдээ баримтыг цуглуулж нэгтгэхэд шаардлагатай тогтолцоог бий болгох;</li> <li>• Оролцогч талуудын шаардлагад тулгуурласан дотоод, гадаад тайлагналын зохих хугацаа, давтамж, хэлбэрийг тодорхойлох;</li> <li>• Банк болон түүний оролцогч талуудын хооронд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал солилцох</li> </ul> <p>Банк нь Даяар тайлагнах санаачлага зэрэг тайлагналын олон улсын сайн туршлагын стандарт, тайлагналд тавигдах үндэсний холбогдох шаардлага, Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудад тусгасан стандартыг дагаж мөрдөх шаардлагатай.</p> |
| Сайн туршлагаас   | <ul style="list-style-type: none"> <li>• Экваторын зарчмууд /The Equator Principle/ нь банкнаас тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн асуудлыг тайлагнах удирдамж бөгөөд хэрхэн тайлагнах жишээг харуулсан байдаг (<a href="#">Холбоос</a>)</li> <li>• НҮБ-н Байгаль орчныг хамгаалах хөтөлбөрийн Санхүүжилтийн санаачлага /UNEP-FI/-аас хөгжиж буй зах зээлийн хүрээнд тогтвортой байдлын тайлагналын хэд хэдэн жишээг тусгасан баримт бичгийг боловсруулсан: Тогтвортой байдлын менежмент ба тайлагнал: Хөгжиж буй эдийн засаг болон зах зээлд санхүүгийн</li> </ul>  |

| Зарчим 7                                 | Ил тод байдал, хариуцлагыг дэмжих   |
|--|---|
|  | <p>байгууллагын хүртэх үр шим /Sustainability well: Sustainability Management and Reporting: Benefits for Financial Institutions in Developing and Emerging Economies/ (Холбоос)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүлэмжийн хийн протоколын бүтээгдэхүүний бүртгэл ба тайлагналын стандартын Мэдээлэл харилцааны салбарын хавсралт /ICT sector Supplement to the Greenhouse Gas (GHG) Protocol Product Accounting and Reporting Standard/: Бүтээгдэхүүний үр ашигтай байдлын стандарт нь банк, түүний харилцагчид хүлэмжийн хийн ялгарлын талаар илүү хариуцлагатай тайлагнахтай холбоотой сайн жишээ юм. (Холбоос)</li> </ul>  |
| Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд | <p>Банк энэхүү зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Олон нийтэд ил тод болгох тайланд Тогтвортой санхүүжилт (ToC)-ийн зарчмуудын хэрэгжүүлэлтийн явц, амжилт, хүндрэл бэрхшээлийн талаар оруулахын зэрэгцээ зарчим тус бүрт хамаарах байгаль хамгаалал, хүний болон хөдөлмөрийн эрх, соёлын өв, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжих, санхүүгийн хүртээмжийн асуудлыг мөн тусгаж, жил бүр гаргах. Ингэхдээ доор дурдсан буюу бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: <ul style="list-style-type: none"> <li>○ Холбогдох мэдээ, баримтыг цуглуулахад хэрэглэгдэх хэмжигдэхүүн, өгөгдлийн шаардлагыг тодорхойлох;</li> <li>○ Банкны ахлах ажилтан, стратегийн шийдвэр гаргагч этгээдүүдэд дотоодын тайлан мэдээллийг тухай бүр хүргэж байх;</li> <li>○ Банкны оролцогч талуудад зориулан тогтвортой байдлын тайланг тухайн жилийн тайлангийн нэг хэсэг хэлбэр, бие даасан хэлбэрээр хэвлэн хүргэж байх. Тайланг цахим хэлбэр, хэвлэмэл байдлаар гаргаж болно;</li> <li>○ Банк нь зарчим тус бүрийг хэрэгжүүлэх явцад ямар санаачлага, бодлогыг авч хэрэгжүүлсэн, ямар ахиц дэвшил гаргасан (үндсэн хэмжигдэхүүн ба нөлөөллийн хэмжүүр) болохыг тоймлон харуулах хэрэгтэй. Мөн шаардлагатай гэж үзвэл зарчмуудыг хэрэгжүүлэх явцад гарсан ололт амжилт, хүндрэл бэрхшээлийг тусгана.</li> </ul> </li> </ul> |



| Зарчим 8  | Манлайлан үлгэрлэх   |
|---|--|
| <p>Бид харилцагчиддаа тавьж буй шаардлагыг өөрийн дотоодын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллана.</p> |  |
| <p>Тайлбар</p> <p>Хэрэгжүүлэлт</p> <p>Сайн туршлагаас</p>   | <p>Банк нь Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн 1-7-р зарчмуудыг өөрийн дотоод үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Энэ нь банкнаас харилцагчийн үйл ажиллагаанд тавих шаардлагуудыг даган мөрдсөнөөр өөрөө тогтвортойгоор үйл ажиллагаагаа эрхлэн явуулах үүргээ биелүүлж, үлгэрлэж буй хэрэг болно. Энд мөн банкны дотоод үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үр дүнтэй зохицуулах, ажилтнуудад шударга хандаж, хүмүүнлэгийн ажлаар дамжуулж орон нутгийн иргэдийг дэмжих зэрэг асуудал багтдаг.</p> <p>Банк нь өөрийн дотоод үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг зохицуулах шаардлагатай тогтолцоог бий болгох шаардлагатай. Түүнчлэн, нийгмийн өндөр хариуцлагатай байж, сайн байгууллага, иргэн байх тал дээр өөрийн байр суурь, үүргийг тодорхойлж, нийгэмд эерэг нөлөөллийг үзүүлж байх юм.</p> <p>Энэ зарчмыг хэрэгжүүлэхдээ банк нь өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлж, зохицуулах аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх болно. Уг тогтолцоо нь олон улсын сайн туршлага бүхий стандартуудыг дагаж мөрдөх бөгөөд үүндээ банкны ажилтан, гэрээт гуравдагч тал, ханган нийлүүлэгч нарыг давхар хамруулна.</p> <p>Банк нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирдлагыг зохих ёсоор чиглүүлэх бодлогын тогтолцоог боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд зарим хэсэгт ажилтан, ханган нийлүүлэгч нарын асуудлыг тусгана. Холбогдох баримт бичигт доор дурдсан болон бусад асуудлыг харгалзан тусгасан байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Банкны дотоодын үйл ажиллагаанаас шууд үүсэх байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл /барилга байгууламж, эрчим хүч (тухайлбал: түлш, цахилгаан гэх мэт), байгалийн нөөц ашиглалт (ус, хаягдал ба цаас зэрэг) ба нүүрсхүчлийн хийн ялгаруулалт гэх мэтийг хэмжиж, удирдах тодорхой тогтолцоотой байх;</li> <li>• Ажилтантай зүй зохистой харьцаж, оролцоог хангах (тухайлбал: ажилтаны эрхийг хүндэлдэг, тэдгээрийн хөгжил боловсролд анхаарлаа хандуулсан хүний нөөцийн хүчтэй бодлоготой байх);</li> <li>• Байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотойгоор ажилтнуудынхаа мэдлэгийг нэмэгдүүлж, чадавхижуулах дотоод механизмыг бий болгох;</li> <li>• Ханган нийлүүлэгч (ялангуяа, үндсэн ханган нийлүүлэгч), гэрээт гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг хэрхэн зохицуулахаа харуулсан шалгуур (тухайлбал, ёс зүйн дүрэм) ба стандартын шаардлагыг бий болгох;</li> <li>• Хандив/ ашгийн бус түнштэй хамтран ажиллах (тухайлбал байгаль орчин, нийгэмд оруулах хандивын төсөл), орон нутагт оруулах хөрөнгө оруулалт (тухайлбал ажилтнуудын сайн дурын ажил ба хандив гэх мэт) стратеги, тусгай сан, эх үүсвэрийг бий болгох.</li> </ul> <p>Стандарт Чартерэд Банк: Тус банк нь хариуцлагатай компани болохын хувьд бизнесийн бүхий л хүрээндээ тогтвортой байдлын удирдлагын дэвшилтэт цогц аргачлалыг ашигладаг. <a href="#">(Холбоос)</a></p> <p>Шотландын Роял Банк нь бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа тогтвортой байдлыг авч үзэх ёс зүйн дүрмийг саяхан боловсруулсан. <a href="#">(Холбоос)</a></p> <p>HSBC банкны Усны хөтөлбөр /Water Programme/ – Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтарсан таван жилийн хөтөлбөр, Earthwatch ба WaterAid зэрэг нь банкнаас хөгжлийн чухал зорилтуудтай холбоотой хүмүүнлэгийн санаачлага хэрэгжүүлэхэд хэрхэн хамтран ажиллах, ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, тэдгээрийг сайн дурын ажилд хамруулахийн сайн туршлага юм. <a href="#">(Холбоос)</a></p> |



| Зарчим 8  | Манлайлан үлгэрлэх  |
|---|---|
| <p>Хэрэгжүүлэлттэй холбоотой хийгдэх ажлууд</p> | <ul style="list-style-type: none"> <li>• ISO14001: Бизнес ба байгууллагын байгаль орчны менежментийн тогтолцоо, стандартууд. (Холбоос)</li> <li>• HSBC банкны Байгаль орчны үр ашгийн хөтөлбөр /Environmental Efficiency at HSBC/ нь банк эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж буйгийн сайн жишээ. (Холбоос)</li> <li>• Усны ашиглалтын үнэлгээний гарын авлага /The Water Footprint Assessment Manual / 2011, Ус ашиглалтын сүлжээ: үнэлгээний аргачлал ба авч хэрэгжүүлэх боломжит арга хэмжээнүүд. (Холбоос)</li> <li>• Хүлэмжийн хийн протокол санаачлага /Greenhouse Gas Protocol Initiative/: Байгууллагын хүлэмжийн хийн ялгаруулалтыг зохицуулах стандарт, аргачлал. (Холбоос)</li> <li>• Ойн аж ахуйн хяналтын зөвлөл (ОААХЗ): цаас болон цаасан бүтээгдэхүүнд тогтвортой байдлын гэрчилгээ олгох удирдамжийн дүрэм ба аргачлал. (Холбоос)</li> <li>• Стандарт банк нь олон нийтэд чиглэсэн хөрөнгө оруулах (сайн дурын ажилд оролцох болон санхүүгийн хандив тусламж үзүүлэх) үйл ажиллагаанд банкны ажиллагсдыг хэрхэн хамруулахыг харуулсан сайн жишээ юм. (Холбоос)</li> </ul> <p>Банк энэхүү зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг зохицуулахдаа баримтлах ерөнхий аргачлал, ёс зүйн дүрмийг боловсруулахдаа дор дурдсан болон бусад асуудлыг харгалзан тусгана: <ul style="list-style-type: none"> <li>• Ханган нийлүүлэгчийн менежмент, нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалт, эрчим хүч/нөөцийн ашиглалтын талаар баримтлах банкны байр суурийг тусгасан бөгөөд олон улсын стандартад нийцсэн байгаль орчин, нийгмийн менежментийн систем (тухайлбал: ISO 14001 гэрчилгээ)-ийг боловсруулна;</li> <li>• Банктай хамааралтай тогтвортой байдлын талаар ойлголт, мэдлэг олгох боловсон хүчин бэлтгэх, ажилтнуудыг сургахад хөрөнгө гаргах;</li> <li>• Нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалтын нөөц бололцоог гаргаж, зарцуулах бодлого;</li> <li>• Банкны байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг жил тутам тайлагнахдаа сөрөг нөлөөллийг бууруулах урт хугацааны зорилт, гүйцэтгэлийг жил жилээр сайжруулах арга хэмжээг тусгах нь зүйтэй юм.</li> </ul> </li> </ul> |

## **САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН БОЛОН АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ**

Санхүүжүүлэхийг хориглосон болон анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагааны жагсаалтыг олон улсын тэргүүн туршлагауд, түүнчлэн Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг судлан боловсрууллаа. Энэхүү жагсаалтыг үндэсний болон олон улсын санхүүжилтийн боломжуудыг харгалзан боловсруулсан тул жагсаалтанд Монгол Улсад санхүүжилт авдаггүй зарим үйл ажиллагаа тусгагдсан болно.

Уг жагсаалт нь дараах 2 төрлийн жагсаалтаас бүрдэнэ.

- а) Банк нь санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт;
- б) Анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагааны жагсаалт:

### **А) Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт**

1. Монгол Улс болон олон улсын хууль, конвенци, гэрээгээр хориглосон үйл ажиллагаанууд;
2. Сэтгэцэд нөлөөлөх ургамалын тариалан, хуулийн зохицуулалтгүй хар тамхины үйлдвэрлэл, тээвэрлэлт ба худалдаа;
3. Хууль бус мөрийтэй тоглоом буюу казиногийн бизнес;
4. Садар самууны сурталчилах, дэмжин зохион байгуулах;
5. Албадан хөдөлмөр эрхлэлтийн аюултай болон мөлжлөгийн хэлбэрүүд, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүд, ялгаварлан гадуурхал болон хуулинд заасан ажилчдын эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтран хэлэлцээр байгуулах эрхийг хязгаарласан аливаа үйл ажиллагаа;
6. Галт зэвсэг ба дайны зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа;
7. Сүлжээний маркетинг ба пирамидийн бүтцээр дамжуулан орлого олох;
8. Тухайн орны зохих лиценз ба зөвшөөргүйгээр улс дамжин экспорт, импорт ба худалдаа хийх;
9. Олон улсын ба үндэсний тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа эрхлэх;
10. Биологийн олон янз байдлын хамгаалал, түүх соёлын дурсгалтай холбоотой олон улсын конвенци ба гэрээ хэлэлцээрээр хориглосон үйл ажиллагаанууд;
11. Шөрмөсөн чулуу ба үүнийг агуулсан аливаа бүтээгдэхүүний хэрэглээ;
12. Полихлорт бифенил агуулсан аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба худалдаалах;
13. Олон улсад хориглосон озон задлагч бодис агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах;
14. Олон улсад хориглосон эм, шахмал эм, шавжны хор, бусад хортой бодис үйлдвэрлэж, худалдаалах;
15. CITES-н конвенциар хориглосон зэрлэг амьтан, ургамлын эд эрхтэнг худалдаалах;
16. Тогтвортой бус аргаар загас агнах (жишээлбэл тэсрэх бодис ашиглах, цэнгэг усны загасыг тогтвортой бус аргаар агнах гэх мэт);
17. Олон улсад хориглосон хог хаягдлыг тээвэрлэж устгах;
18. Байгаль хамгааллын өндөр ач холбогдолтой ойн сан бүхий газраас мод бэлтгэх (жишээлбэл Хангайн бүсийн ой мод) болон тусгай хамгаалалттай газар дээр мод бэлтгэх төхөөрөмж худалдаалах;
19. Тогтвортой менежментгүйгээр ойн сан бүхий газраас гуалин мод бэлтгэх, мод болон модон бүтээгдэхүүн худалдаалах;
20. Роттердамын болон Стокгольмын конвенцид тусгасан хориотой зүйлс.

## **В) Анхаарах (дью дилиженс үнэлгээ хийх) шаардлагатай үйл ажиллагааны жагсаалт**

Энэхүү жагсаалтын хүрээнд банк нь зээл олгох шийдвэр гаргахдаа банкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудал хариуцсан нэгж эсхүл ажилтны дүгнэлтийг авна.

1. Иргэдийг албадан нүүлгэн суурьшуулахтай холбоотой аливаа үйл ажиллагаанууд;
2. Тухайн орон нутгийн иргэдийн амьжиргаанд шаардлагатай газрын маргаантай, тусгай хамгаалалттай газар нутагтай ойролцоо явагдах аливаа үйл ажиллагаа, устах аюулд орсон, устаж болзошгүй биологийн олон янз байдлын төрөл зүйлийн унаган тархац нутагт болон экологи, эдийн засгийн хувьд чухал газар нутагт явагдах аливаа үйл ажиллагаа;
3. Археологи, түүх ба соёлын дурсгалыг устгаж гэмтээж болзошгүй үйл ажиллагаанууд;
4. Хувирсан амьд организмыг худалдаалах, нутагшуулах;
5. Цөмийн эрчим хүч (уран олборлох, боловсруулах, баяжуулах, цөмийн түлш хадгалах, тээвэрлэх, цөмийн эрчим хүч түгээх);
6. Цацраг идэвхит бодис үйлдвэрлэх, худалдаалах ба цацраг идэвхит хаягдлыг хадгалах, тээвэрлэх;
7. Газрын тос, байгалийн хийн томоохон төслүүд мөн байгалийн хий дамжуулах хоолойн барилга;
8. Өнгөт болон өнгөт бус металлын олборлолтын томоохон төслүүд;
9. Усан цахилгаан станц ба дулааны станцын барилга;
10. Ахуйн хог хаягдал ба аюултай хог хаягдалын устгал;
11. Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа төслүүд, нийгэм, эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа төслүүд;
12. Шар айраг, дарснаас бусад архи согтууруулах ундаа ба тамхины үйлдвэрлэл ба худалдаа.